**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ 2025 ОНД ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2025 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Өөрийн үнэлгээ | Дээд газрын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана.** | | | | | | | | |
| 3.1.1. | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулан, орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулах. | - | Угийн бичгийн хөтлөлтийн хувь | 2018 оны судалгаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт | Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна. Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна. | Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах 1 багштай гэрээлэн Бор-Өндөр суманд ажиллуулж байна.<br><br>Угийн бичгийн хөтлөлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 16 удаагийн сургалт зохион байгуулж 1448 иргэнийг хамруулсан.<br>Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог 25 хувиар нэмэгдүүлсэн. | 100% | Хэрэгжсэн |
| **3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар:** | | | | | | | | |
| 3.1.2.1. | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; | 20,200.0 | 1. Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1<br>2. Гэр бүлийн | 2024 онд гарсан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг 2, зөрчлийн тоо 343 | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснэ | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах ажлын хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн харилцаатай өрхтэй ажиллах 14 заалттай төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг сумдад хүргүүлсэн. Хүчирхийллийг бууруулах арга хэмжээний | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь | | эр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна. | төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь.<br>2024 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар гэмт хэрэг, зөрчил 296 бүртгэгдэж байсан бол 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил 230 бүртгэгдээд байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг, зөрчил 22,2 хувиар буурсан байна. | | |
| 3.1.2.2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах. | | 1.Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь | 2024 онд урьдчилан сэргийлэх 5 удаагийн нөлөөллийн ажилд 1362 өрх хамруулсан. | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна. | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зан үйлд нөлөөлөх сургалтад 5781, гэр бүлийн боловсрол олгох сургалтад 2317, хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтад 2904, зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад 560 иргэн хамруулсан. Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 42 (24 хүүхэд, 18 насанд хүрэгч) бүлгийн зөвлөгөөнд 103 хүн хамруулсан.<br>Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил 230 бүртгэгдээд байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг, зөрчил 22,2 хувиар буурсан байна. | 100% | Хэрэгжсэн |
| 3.1.2.3. | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсрол олгох; | Орон нутгийн төстийн хөрөнгөөр | Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | - | Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын хүртээмж, чанар | Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний бүсийн төвийг 2 суманд байгуулсан. Тус төвүүдийг байгуулахад орон нутгийн төсвөөс 60,0 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэж, гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр дамжуулан “Монгол- | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжирна. | Өрх" сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран сум, орон нутгийн гэр бүлд хүргэх явуулын үйлчилгээг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 19 суманд хүрч ажиллаж нийт 4613 хүнд үйлчилгээг хүргэсэн. Үүнд сэтгэл зүйн боловсрол олгох, хууль эрх зүйн мэдлэг дээшлүүлэх сургалтад 393 насанд хүрэгч, эрсдэлээс өөрийгөө сэргийлэх сургалтад 1911 ЕБСургуулийн сурагч, 804 СӨББайгууллагын хүүхэд, лекцэнд 1277, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд 125 хүн, бүлгийн зөвлөгөөнд 103 хүн байна. Нийт 6 сумын эрсдэлт 204 өрхөөс, 150 өрхийн 239 хүүхэд, насанд хүрэгчдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн. Энэ нь эрсдэлт өрхийн 73,5 хувийг эзэлж байна. | | |
| 3.1.2.4. | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах; | Орон нутгийн төстийн хөрөнгөөр | 1 .Батлагдсан төсөв- 100%<br>2.Зардлын хуваарилалт , үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | 2024 онд баталсан төсөв. | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар | 2025 онд орон нутгийн төсвөөс Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардалд 50.0 сая, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 12 сумын хамтарсан баг 38,7 сая төгрөгийг батлуулж үйл ажиллагаандаа зарцуулсан. 18 сум, 5 тосгонд 29 хамтарсан баг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж ажилласан ба хамтарсан багийн үйл ажиллагааны | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдсэн байна. | төлөвлөгөөний хэрэгжилт 90,5% дүгнэгдсэн бөгөөд 29 хамтарсан багийн үйлчилгээнд нийт 198 хүүхэд, 61 насанд хүрэгч хамрагдаж хамгааллын үйлчилгээ авсан. | | |
| **3.1.3. Хүүхдийн эрхийн талаар:** | | | | | | | | |
| 3.1.3.1. | Хүүхдийн эрх, хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх; | 1,779,470.4 | 1. Төлөвлөгөө баталсан эсэх 2.Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 5 дугаар хуралдааны 9 дүгээр тогтоолоор Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбар дундын "Ирээдүйн эзэд" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, ажлын хэсгийг салбар бүрийн төлөөллийг оролцуулан аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/239 дүгээр захирамжаар батлуулж, сумдын Засаг дарга нарт хяналтад авч ажиллах чиглэлийг хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 91,5 хувьтай байна. | 91.5% | Хэрэгжсэн |
| 3.1.3.2. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх; | | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | 2024 онд хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 7800 хүүхэд хамруулсан. | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 хувиар өссөн байна. | Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх хөгжлийн төв болон Ид шидийн орон хүүхэд хөгжлийн төвийн нийт 13 төрлийн дугуйланд 3414 хүүхэд, 18 сум, 4 тосгонд 7164 хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан. Аймгийн хэмжээнд нийт хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 9750 хүүхэд хамруулахаас 14774 хүүхэд хамруулсан. | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3.3. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухайн шатны ИТХ-аар батлуулах; | | Баталсан төсвийн хэмжээ | 2024 онд баталсан төсөв | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна. | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн төлөвлөгөөг 4 жилийн хугацаатай, 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Хэнтий аймгийн аймгийн Засаг даргын орлогчоор батлуулж, 2025 онд хэрэгжүүлэх 13 ажил төлөвлөснөөс хэрэгжилт 83,3 хувьтай байна. | 83.3% | Хэрэгжсэн |
| 3.1.3.4. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах; | | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо<br>2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/ | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна. | Монгол улсад хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярыг угтаж Хэнтий аймагт урьдчилсан тооцоогоор 60 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай хүүхдийн зуслан- сургалтын бааз барих эхлэл тавигдсан бөгөөд уг ажлыг "Зүрхтэй зүтгэлтэй хүмүүс" төрийн бус байгууллагын хамт олны зүгээс дэмжиж хамтран ажилласан.<br>"Зүрхтэй зүтгэлтэй хүмүүс" төрийн бус байгууллагын хамт олон болон сумдын хүүхэд гэр бүлийн 24 нийгмийн ажилтнаар дамжуулан аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг сурталчлах ажлыг 9,10 дугаар сард зохион байгуулж аймгийн хэмжээнд 18 сум 1 тосгоны 51 аж ахуй нэгж, 105 иргэн, 43 төрийн байгууллагын албан хаагчдад танилцуулсны үр дүнд нийгмийн хариуцлагын хүрээнд хүүхдийн сургалтын | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бааз-зуслан барих ажил 82,122,045 төгрөгийн хөрөнгө босгож зарцуулагдсан. | | |
| 3.1.3.5. | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах; | | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | | Хүүхдийн оролцооны Байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Хэнтий аймгийн хүүхдийн зөвлөл, Поларис, Скаут, Өсвөрийн сэргийлэгч, Өсвөрийн сэтгүүлч, Өсвөрийн улаан загалмай, Хүслэн ХОУЗ, Лидер сурагч академи зэрэг 8 байгууллагуудын удирдах зөвлөлийг хурал, уулзалт хийх байр танхим, арга зүйгээр хангаж ажилласан.<br><br>Хүүхдийн саналыг сонсох уулзалт, хэлэлцүүлэг, саналыг хайрцгийг сум бүр хэрэгжүүлсэн бөгөөд “Хүүхдээ сонсъё” арга хэмжээнд аймгийн хүүхдийн зөвлөл, оролцооны байгууллагын төлөөлөл, тусгай хэрэгцээт хүүхдийн төлөөлөл 40 сурагч, "Байгальд ээлтэй хүүхдүүдийн чуулга уулзалт"-д 72 хүүхэд, “Сэцэн ханы ирээдүй” зүүн бүсийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрийн үеэр “Хүүхдээ сонсъё” арга хэмжээг зохион байгуулж, 117 хүүхэд хамруулж санал сонссон. “Засаг даргад хүргэх миний үг” 100 санал-100 шийдэл арга хэмжээг зохион байгуулж 18 сум, 1 тосгоны 2102 хүүхдийн саналыг сонсож аймгийн хэмжээнд 459 санал гарсныг шийдвэр гаргах | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түвшинд хүргэж 98 асуудлыг аймаг, сум, орон нутаг, сургуулийн удирдлагууд бүрэн шийдвэрлэж ажилласан үр дүнд хүрсэн. | | |
| 3.1.3.6. | “Олон нийтийн байцаагч''-ийг ажиллуулж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх. | | 1.Олон нийтийн байцаагчийн тоо<br><br>2. Илрүүлсэн хүүхдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна. | Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/33 дугаартай захирамжаар Хэрлэн сумын 6 багт 42 хэсгийн ахлагчийг “Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч”-аар томилон ажиллуулсан.<br>Хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчдыг чиглүүлэх 4 удаагийн сургалт, “Та хаана хандах вэ?” 1 удаагийн аян зарлаж давхардсан тоогоор 106 хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчдыг арга зүйгээр хангасан бөгөөд эдгээр байцаагчид эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлсэн тухай бүр 108 тусгай дугаарын утсанд мэдээлж ажилласны үр дүнд 108 тусгай дугаарын утасны дуудлага 243 болж өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 156 дуудлагаар нэмэгдсэн буюу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 55.7 хувиар өссөн байна. | 100% | Хэрэгжсэн |
| **3.1.4. Хүүхэд хамгааллын талаар:** | | | | | | | | |
| 3.1.4.1. | “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулж, салбар бүрд | 384,663.3 | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр, | Аймгийн хэмжээнд төрийн 192 байгууллагын дэргэд эцэг эхийн зөвлөл үйл ажиллагаа явуулж байгаа | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдүүлэх; | | байгууллагын тоо | | хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд<br><br>хүүхэд хамгааллын бодлогыг мөрдүүлсэн байна. | бөгөөд 189 байгууллага хүүхэд хамгааллын бодлого батлан, нийт эцэг эхийн зөвлөлийн 98.4 хувь нь тогтмол үйл ажиллагаатай болсон байна.<br>Хувийн хэвшлийн 22 байгууллага хүүхэд хамгааллын бодлого батлан мөрдөж ажиллаж байна. | | |
| 3.1.4.2. | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх; | | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж, үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйлчилгээг 629 хүүхдэд хүргэж мэдээллийн сангийн программд бүртгэлтэй байна. Үүнээс 236 хагас, бүтэн өнчин хүүхэд бүртгэгдсэнээс 3 удаагийн гэр эргэлт хийх ажлыг зохион байгуулж тус хүүхдүүдийн 90 хувьд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэж ажилласан.<br>2025 оны байдлаар аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 405 хүүхэд, Үрчлэгдсэн нийт 9 хүүхэд байна. Эдгээр хүүхдүүдэд хяналт тавих, эрсдэлээс сэргийлэх зорилгоор гэр эргэлт хийх ажлыг харъяа сум, багийн хамтарсан багууд тогтмол хийж байна. | 100% | Хэрэгжсэн |
| 3.1.4.3. | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилж, хэрэг хянан шийдвэрлэх | | 1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв;<br><br>2. Хууль зүйн хорооны | 26.7 хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний А/127 дугаартай захирамжаар 13 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэх; | | үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | | бүрэн хүргэсэн байна. | Хууль зүйн хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөн 25,0 сая төгрөгийн төсвийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай байна.<br><br>Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд нийт 44 хүүхэд бүртгэлтэй байна. Үүнээс: гэрчээр-10, хохирогч 25, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3, сэжигтэн-6 нийт 44 хүүхдийг хяналтад авч давхардсан тоогоор 121 удаагийн үйлчилгээ үзүүлсэн. Хохирогч 5 хүүхдийн өмгөөллийн зардалд 5,5 сая, гэмт хэргийн холбогдогч 2 хүүхдийн өмгөөллийн зардалд 2,5 сая төгрөг зарцуулсан Хорооноос үйлчилгээ авах шаардлагатай 44 хүүхдэд 100 хувь үйлчилгээг хүргэсэн. | | |
| 3.1.4.4. | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих; | | 1.Хяналт, шалгалтын тоо,<br><br>2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь | - | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна. | 2025 онд Хэнтий аймгийн хэмжээнд 42 хурдан морины уралдаан зохион байгуулагдаж, уралдаан тус бүрт хүүхдийн аюулгүй байдлыг хангуулахаар хяналт тавьж, стандартын бус шаардлага хангахгүй дугуйн болон роликны малгай өмссөн 25, хамгаалалтын өвдгөвч, тохойвч дутуу хагарч цуурсан зөөлөвчгүй 18, станц шүгэл биедээ авч | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уралдаанд гарахыг завдсан 8 зөрчлийг илрүүлэн, нийт 51 зөрчлийг газар дээр нь 100% бүрэн арилгаж хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолоор хориглосон хугацаанд хурдан морины уралдаан зохион байгуулсан 1 зөрчлийг илрүүлж шалган, 1 иргэнд 2,0 сая төгрөгийн торгууль оногдуулж арга хэмжээ авсан. 18 сум, 5 тосгон болон байгууллагын цахим хуудаст өвлийн уралдаан хориглосон ЗГ-ын 57-р тогтоол, АЗД-ын захирамжийг 2 удаа байршуулж нийт 2568 хүнд хүргэсэн.<br>Зохион байгуулагдсан 42 удаагийн хурдан морины уралдааны үеэр нийт 26 хүүхэд хурдан мориноос унасан тохиолдол бүртгэгдэж, эдгээр хүүхдүүдээс хөнгөн гэмтэл буюу биеийн ил харагдах хэсэгт зулгарч, шалбарсан 8, гэмтэл бэртэл аваагүй 18 хүүхэд нь байна. Мориноос унасан 26 хүүхдэд эмнэлгийн байгууллагаас анхан шатны тусламжийг 100 хувь үзүүлж, эцэг эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгсөн.<br>Хурдан морины ажил хийж явцад 3 хүүхэд, хурдан морины сунгааны үед 1 хүүхэд гэмтэл авч тус 4 хүүхдэд болзошгүй эрсдэлийн даатгалаас | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6,030,000 төгрөгийн нөхөн төлбөр авсан. Гэмтэл авсан 4 хүүхдийн эрүүл мэндийн байдал хэвийн болсон гэх мэдээллийг асран хамгаалагч нар өгсөн. 2025 онд хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг 100 хувь хангаж ажилласан. | | |
| 3.1.4.5. | Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх; | | 1-Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага | Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна. | Галт түймэрт өртсөн Баян-Овоо, Дархан, Хэрлэн сумын нийт 3 сумын 10 өрхөд хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлох, зураглал гаргах түргэвчилсэн үнэлгээний маягтын дагуу үнэлгээ хийж, кейс төлөвлөгөө гарган, үнэлгээний дүгнэлтийн дагуу 24 хүүхдэд шаардлагатай 9,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж үйлчилсэн. | 100% | Хэрэгжсэн |
| 3.1.4.6. | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин | | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | "Хамтдаа, шалгая, хамгаалъя" аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж 16 сум , 1 тосгоны нутаг дэвсгэрт байрлах цэцэрлэгийн эзэмшлийн 25, сургуулийн эзэмшлийн 7 нийтийн эзэмшлийн 37 нийт 69 тоглоомын талбайд MNS 6751:2019 стандартын дагуу тоглоомын талбайн аюулгүй байдлын хяналтын мэдээлэх хуудсаар сум багийн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнууд хяналт шалгалтыг | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлэх; | | | | | хийж 26 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулах улсын байцаагчийн дүгнэлт хүргүүлж 17 зөрчлийг арилгуулсан.<br>Уг аяны хүрээнд орон сууцны гэрэлтүүлэг, цахилгаан сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг, ус ихээр тогтдог цэг зэрэг нийтдээ 561 цэгт хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж орчны эрсдэлийн үнэлгээ хийж 68 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах албан бичгийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж ажилласны үр дүнд 47 зөрчлийг бүрэн арилгасан. | | |
| 3.1.4.7. | Хүүхдийн хөгжлийн сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ, сүм хийд, худалдаа үйлчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах. | | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | - | Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна. | Хэрлэн сумын “Оюу” хүүхэд харах үйлчилгээний төвд хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд хамрагдаж байна. Хүүхэд харагчийг 9 удаа арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд 3 удаа хяналт шалгалт хийсэн.<br>Нийт 18 сум, 1 тосгоны 17 буддын хийд, 22 сүм, чуулганд 2025 оны 11 дүгээр сарын 18-21-ний хугацаанд 1 удаа хяналт шалгалт хийж, шалгалтаар хүүхэд хамгааллын бодлого батлаагүй-37, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл аваагүй хүүхэд цуглуулдаг-2, үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан гаргадаггүй-39, камержуулалт хангалтгүй-38, гадаад дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийгээгүй- | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 39, харуул хамгаалалт байхгүй-39, нийт 39 сүм, хийдэд хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж чиглэлийг газар дээр нь өгч ажилласан. | | |
| **3.2. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана;** | | | | | | | | |
| **3.2.1. Хөдөлмөрийн харилцааны талаар:** | | | | | | | | |
| 3.2.1.1. | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | 2,526,654.9 | ААНБ-ын тоо Ажилтан албан хаагчийн тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан. | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойголтыг нэмэгдүүлж, хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулах зорилгоор 26 ААН, байгууллагын 1835 ажил олгогч, ажилтанд мөн Батширээт, Баян-Адарга, Баянхутаг, Галшар сумын малчдад сургалт арга хэмжээг зохион байгуулан ажилласан. | 100% | Хэрэгжсэн |
| 3.2.1.2. | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | 1.Хамрагдсан ААНБ-ын байгуулагын тоо 2.Зохион байгуулсан сургалтын тоо | - | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн | “Ерөн ес” хоршоо, “Өгөөмөр зөв зам” ХХК, “Ханбүргэд хаан” 2 ХХК-ийн хүсэлтийн дагуу мэргэжлийн багш, мэргэжилтнүүд хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг 12 хоногийн хугацаанд амжилттай хэрэгжүүлэн ажилласан. Нийт 9 сургалт зохион байгуулж 9,900,000 төгрөгийг зарцуулсан. | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | | | |
| 3.2.1.3. | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | Хөдөлмөрийн эрхийн маргаанаас урьдчилан сэргийлэх сургалт, хууль сурталчлах ажлууд хийсэн. Энэ онд 1 иргэний гомдлыг Аймгийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах 3 талт хороо хүлээн авч маргааныг хянан, эвлэрүүлэн шийдвэрлэсэн. Хөдөлмөрийн эрхийн маргаан өмнөх оноос 1-ээр буурсан. | 100% | Хэрэгжсэн |
| 3.2.1.4. | Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачилгатай ажиллах. | | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | 2024 онд Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлэн хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийг 7-н байгууллага хамтын гэрээ баталгаажуулан ажилласан. | Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж, бүртгэж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлэн 12 байгууллагын хамтын гэрээ хэлэлцээрийг хянан баталгаажуулан мэдээллийн сан үүсгэн ажилласан. | 100% | Хэрэгжсэн |
| **3.2.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар:** | | | | | | | | |
| 3.2.2.1. | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн | 1,747,662.7 | Бодлогын баримт бичгийн тоо, Судалгаа, мэдээллийн тоо | Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж, шаардлагатай бодлого, үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна. | Орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, чиглэлүүдийг тодорхойлох зорилгоор 18 сум 3 тосгоны хэмжээнд 140 ААН, байгууллагаас судалгаа авч нэгтгэн ажилласан. Үүнд: Түүхэн аялал жуулчлал ба соёлын үйлчилгээ, Барилга, | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | | | | | бүтээн байгуулалт, Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, Малын түүхий эд боловсруулах үйлдвэрлэл, Газар тариалан, худалдаа үйлчилгээ, Уул уурхай, мал аж ахуй зэрэг жижиг, дунд үйлдвэрлэл, гараанй бизнесүүд байна. Энэ салбаруудыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрт иргэдийг хамруулах, ажлын байранд зуучлах ажлуудыг АЗДҮАХ болон холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгасан. | | |
| 3.2.2.2. | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах; | | Судалгаа, мэдээллийн тоо | Албан ёсны статистик (Ажиллах хүчний судалгаа) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан(EJOB систем) | Аймгийн/сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна. | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 18 сум, 3 тосгоноор гаргаж шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт нийлүүлэлтийг салбар, мэргэжил бүрээр ангилж үзэхэд нэн шаардлагатай дараах ажлын байрыг эрэмбэлж үзвэл:<br><br>Уул уурхай, олборлолтын салбарт хүнд машин механизмын жолооч, хятад хоолны тогооч, бүх төрлийн инженер, геологич, далд ба ил уурхайн туслах ажилтан, цахилгаанчин, гагнуурчин, бүх төрлийн оператор<br><br>Боловсролын салбарт бага ангийн багш, англи хэлний багш, химийн багш, физикийн багш, математикийн багш, сэтгэл зүйч, тусгай хэрэгцээт боловсролын багш, | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэцэрлэгийн багш<br><br>Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн салбарт Агрономич, байгаль хамгаалагч, малын эмч, мал эмнэлгийн эм зүйч<br>Эрүүл мэндийн салбарт хүний их эмч, сувилагч, эм зүйч, лаборант зэрэг ажил мэргэжлүүд хамгийн ихээр эрэлттэй байна. | | |
| 3.2.2.3. | Орон нутгийн хүн амын бүлгүүд (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг)-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог, хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | 1 .Аймгийн ажилгүйдэл, ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br>2.АЙМГИЙН хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь<br>3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө, гүйцэтгэлийн өсөлтийн хувь | Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл 2023 он – Ажиллах хүчний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 5.3%<br>2022 он - ядуурлын түвшин хөдөө 35.6%, аймгийн төв 26.1%, сумын төв 30.6%, хөдөө нутаг41.2% | Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл<br>2024 он<br>-Ажиллах хүчний оролцооны түвшин 64.7 Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 63.4%,<br>-Ажилгүйдлийн түвшин 2.1%<br>2022 он - ядуурлын түвшин хөдөө 35.3%, аймгийн төв 26.1%, сумын төв 30.6%, хөдөө нутаг41.2%<br>Орон нутгийн хүн амын бүлгүүд, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн нөхцөл байдлыг судлахын тулд Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 18 сум, 3 тосгоны ажилгүй нийт 1707 иргэдээс судалгааг авч мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.<br>Тухайн зорилтот бүлгийн иргэдийг санхүүгийн дэмжлэг болон сургалт арга хэмжээнд хамруулан ажилласан. | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2.4. | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах; | | 1.Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 2.Холбогдох арга хэмжээний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%,/2023 он/ | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг хөдөлмөр эрхлэх , аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох дэмжих зорилгоор 5 удаагийн сургалтаар 78 иргэнийг Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт болон хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтад хамруулан 43 иргэнийг байнгын болон түр ажлын ажлын байранд зуучилсан.<br>Мөн мод арчлах,ургуулах арга хэмжээнд Хэрлэн, Батноров, Жаргалтхаан сум, Өлзийт тосгоны зорилтот бүлгийн 74 иргэнийг түр ажлын байранд зуучлан 35,472.000 төгрөгийг зарцуулсан.<br>Зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангаснаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63,4 буюу 0,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | 100% | Хэрэгжсэн. |
| 3.2.2.5. | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ТӨВ (Job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт 2.Холбогдох арга хэмжээний тоо | - | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн | "JOB CENTER" төв нь Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээг 316 иргэнд, бүлгийн сургалтыг 135 иргэнд, 316 ажил хайгч иргэний хөдөлмөр эрхлэх ур | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | чадварт үнэлгээ хийж, 35 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан байна. Албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо 35-аар нэмэгдсэн байна. | | |
| 3.2.2.6. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | 1 .Хяналт шалгалтын тоо 2.Судалгаа, мэдээллийн тоо 3.Холбогдох арга хэмжээний тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/ Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян.хүн /2023 он/ | Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй “Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа”-ны иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 47 иргэнд 450 сая төгрөгийг эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгоод байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 41 иргэнд 200 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгт 30 малчин өрхийг шалгаруулж 240 сая төгрөгийг зарцуулсан. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 47 ахмадын төслийг шалгаруулан, 250 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Нийт 212 байнгын ажлын байр шинээр бий болсон. Албан хөдөлмөр эрхлэлтийн тоо 65-аар нэмэгдсэн. | 100% | Хэрэгжсэн |
| 3.2.2.7. | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инновац шингэсэн шинэлэг | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас шилдэг старт- ап залуучуудад | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, | Инновац шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих зорилгоор 2025 оны 05 | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | | Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 3.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 4.Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашигтай загварАн тоо | олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан. | бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна. | дугаар сарын 19-ний өдөр Зүүн бүсийн залуучуудын дунд зохион байгуулагдсан “Start Up Demo Day-25” арга хэмжээ амжилттай явагдаж, 3-р байранд Хэнтий аймаг "Амиго сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 15 сая төгрөгийн 50%-н эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт хамруулж, байнгын 2 ажлын байр бий болгон ажилласан.<br><br>Шилдэг старт- Апп Залуучуудын гарааны бизнест дэмжлэг үзүүлэх санхүүгийн дэмжлэгт сургалт зөвлөгөө, менторлох үйлчилгээнд 78 залуучууд хамрагдаж, 8 сая төгрөгийг зарцуулсан.<br><br>Шилдэг старт- Апп 2 баг шалгарч, 50%-н эргэн төлөлттэй, 30 сая төгрөгийн санхүүжилт олгож, байнгын 4 ажлын байр бий болгож ажилласан. | | |
| 3.2.2.8. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ түвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо, 2.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 онд ХЭДС- аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая төгрөг зарцуулсан. | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж, | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэхээр шинээр ашиглалтад орсон “Хулан төв”-ийн “Хэнтийд үйлдвэрлэв” борлуулалтын цэгтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, 6,000,000 төгрөгийг зарцуулсан. Тус | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран ажиллах; | | | | хамрагдагсдын тоо, борлуулалт хэмжээ нэмэгдсэн байна. | төвд 23 иргэний бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин 48,560,000 төгрөгийн борлуулалт хийгээд байна. | | |
| 3.2.2.9. | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах; | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжихэд 160.7 сая төгрөг зарцуулсан. | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж, нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна. | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, эхний хурлаар 2024 оны Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хийгдсэн ажлын тайланг танилцуулж, 2025 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлуулсан. 2 дахь хурлаар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэр, ХЭДСангийн төсвийг гишүүдэд танилцуулж, малжуулах арга хэмжээ, түр ажлын байрны квотыг батлуулан ажилласан. Зөвлөлийн гишүүдийг ХЭДСангийн санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт оруулж ажилласан. Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн үйл ажиллагааны сонгон шалгаруулалтад Хэнтий аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбар, Ажил олгогч эздийн холбоо, Залуучуудын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо, Хараагүйчүүдийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн төлөөллүүдийг оролцуулан хамтран ажилласан. | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.2.10 . | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах. | | 1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | 2023 онд ХЭДС- нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн. | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | 10 аж ахуйн нэгж байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр болох 60,016,000 төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлсэн.<br>Хэнтий аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудаас судалгаа авахад 86 байгууллагад 254 ХБИ ажиллаж байна.<br>50 дээш ажилчинтай 41 байгууллагад 90 ахмад настан ажиллаж байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 47 ахмадын төслийг шалгаруулан, 250,000,000 төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ахмадын хөдөлмөр эрхлэлт 60, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт 23-аар нэмэгдсэн байна. | 100% | Хэрэгжсэн |
| **3.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар:** | | | | | | | | |
| 3.2.3.1. | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх. | 2024 оны хэрэгжилт | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна. | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилсан сэргийлэх зорилгоор 6 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж, 658 ажил олгогч, ажилтнуудад сургалт, арга хэмжээг зохион байгуулан | 100% | Хэрэгжсэн |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
